



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Хамрагдсан байгууллага: ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

Тайлангийн код: СХШУДАГ-2026/ДА/06

Говь-Алтай аймаг
2026 он

АГУУЛГА

1.ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Байгууллагын тухай	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ	3
2.1. Аудитын зорилго	3
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт	3
2.3. Аудитын арга, аргачлал	3
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА	4
3.1. Засаглалын удирдлагын талаар	4
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар	5
3.3. Дотоод хяналтын талаар	5
4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР	5
4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт	6
4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт	7
4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт	8
4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүн	9
5. АУДИТЫН ҮР ДҮН	10
6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ	11

1.ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4 “Яам нь харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авна.” Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан “Говь-Алтай аймаг дахь харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ч.Энх-Амгалан ахалж, дотоод аудитор, ахлах мэргэжилтэн Ч.Одгэрэл 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс 04 дүгээр сарын 24-ний өдөр хүртэл хийж гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Б/30 дугаар захирамжаар Засаг даргын дэргэдэх Соёлын хэлтсийг 2 хүний бүрэлдэхүүнтэй анх байгуулсан.

Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 168 дугаар тогтоолоор “Боловсрол, соёл, урлагийн газар” гэснийг “Боловсролын газар, Соёлын хэлтэс” гэж өөрчлөн байгуулах шийдвэр гарсантай холбогдуулан аймгийн Соёлын хэлтсийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан 5 хүний бүрэлдэхүүнтэй болгосон.

Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол, Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Аймаг нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион байгуулалтын бүтэц, дүрэм батлах тухай” 04 дүгээр тушаалаар Соёл, урлагийн газар болж өөрчлөгдөн бүтэц орон тоог 11 болгосон байна.

Засгийн газрын 2024 оны 06 дугаар тогтоолоор Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар болон өргөжиж 16 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 сарын 16-ны өдрийн А/435 дугаар тушаалаар байгууллагын стратеги төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтцийг 16 орон тоотой байхаар шинэчлэн баталсан. Үүний дагуу дээрх баталсан бүтэц орон тооны хязгаарыг мөрдөж, тайлант онд 16 албан хаагч ажилласан байна.

Байгууллагын регистрийн дугаар 3255786, Төрийн сан банканд үндсэн үйл ажиллагааны 100050034003, орон нутгийн санхүүжилтийн 100050034401 дүгээр харилцах дансаар бэлэн бус төлбөр, тооцоог хийсэн.

Аудитад хамрагдах хугацаанд нэгдүгээр гарын үсгийг 2021 оны 07 сарын 23-ны өдрөөс эхлэн дарга С.Цагаанбаатар, хоёрдугаар гарын үсгийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс ерөнхий нягтлан бодогч Д.Бямба-Очир нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийн, дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны зарим үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Үүнд.

- Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт;
- Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт;
- Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт;
- Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг үр дүнд суурилсан эсэхийг хянах;

Хязгаарлалт: Дээрх асуудлаас бусад үйл ажиллагааг хязгаарласан болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж дотоод аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болгосон. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Говь-Алтай аймгийн нийт 23 соёлын байгууллага 2025 онд 454,358.0 мянган төгрөг, 2026 онд 1,305,000.0 мянган төгрөг нийт 1,759,358.0 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгаасаа шийдүүлэн ажилласан байна. Үүнээс Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 550,000.0 мянган төгрөгийг санхүүжилт авсан байна. Орон нутгийн санхүүжилтээр дараах томоохон арга хэмжээнүүдийг уламжлал болгон зохион байгуулаад хэвшсэн байна.

Үүнд: Соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан “Монгол тууль” хайлах өвийг сэргээх, хадгалан, хамгаалах, өвлүүлэн үлдээх зорилгоор Монгол эртний уран зохиолын ноён оргил гэгдэх “Жангар” баатарлаг туулийг хайлах “Туульсын хаан Жангар” арга хэмжээг 2023 оноос хойш жил бүр уламжлал болгон зохион байгуулж, давхардсан тоогоор ерөнхий боловсролын сургуулийн 4050 сурагч, 744 ардын авьяастнаас бүрдсэн нийт 4794 туульч, алтай ятга, морин хуур, товшуур зэрэг хөгжмөөс бүрдсэн 900 гаруй хөгжмийн чуулбартайгаар 4 дэх удаагаа зохион байгуулсан байна.

Залуучуудын хувь хүний хөгжлийг дэмжиж, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, гэр бүл төлөвлөлт, нийгмийн эрүүл мэнд буюу нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох, зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор “АЛТАЙН ЗАЛУУС” ганц бие залуучуудын уулзалтыг аймгийн Засаг даргын санаачилгаар уламжлал болгон зохион байгуулж хэвшлээ.

Соёлын үнэт өв болох угийн бичгийг үеэс үед уламжлан хөтөлдөг монгол зан үйлийг сэргээж, өрх гэр бүлийн уг гарвал, ураг удмын холбоо, элгэн садны хэлхээгээ бэхжүүлэхэд нь дэмжих, монгол хүний удмын санд учирч болзошгүй цус ойртолтын эрсдэлээс сэргийлэх зорилгоор “угийн бичиг, удмын хэлхээ 2024-2028” хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж байна.

“Говь-Алтай 80+” хөтөлбөрийн хүрээнд Монголчуудын эрт дээр үеэс уламжлал болгон хэрэглэж ирсэн аяганы уутны хэрэглээг сэргээх, хүн бүр өв соёлоо эрхэмлэн, байгальд ээлтэй эрүүл амьдралын хэв маягт суралцах зорилготой “Аяганы соёл” аяныг 2024 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

3.1. Засаглалын удирдлагын талаар

Говь-Алтай аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын харьяанд нийт 22 байгууллага соёлын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Ардын дуу бүжгийн Алтай чуулга, Жангар музей, Жангар номын сан, 17 сумын Соёлын төв, 2 тосгоны Соёлын төв.

Нийт соёлын байгууллагуудын батлагдсан орон тоо 237.5 албан хаагч, үүнээс 231.5 албан хаагч ажиллаж байна. Сумын соёлын төвүүдэд нийт 8 орон тоо сул байна. Үүнд: Бигэр сум 1, Дэлгэр сум 1, Тайшир сум 2, Цогт сум 2, Цээл сум 1, Шарга сум 1,

Газар нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд салбарын хууль тогтоомж, бодлого, стратегийг хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргааны бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж 2025 оны үйл ажиллагааг үнэлж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 97.5 хувь, Говь-Алтай аймгийн Засаг дарга 98.5 хувь тус тус дүгнэсэн байна.

Хууль эрх зүйн хүрээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А тушаал 29, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаал 28 нийт 57 тушаал шийдвэрийг төлөвлөн гаргасан байна. Мөн зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийн хүрээнд егр цахим системээр ирсэн бичиг нь 397, явуулсан бичиг 265 байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын урьдчилсан үзлэг”-ийн нэгдсэн дүнгээр 85.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/06 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Бүтэц, орон тооны талаар:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 сарын 16-ны өдрийн “Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуулын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” А/435 дугаар тушаалаар байгууллагын стратеги төлөвлөгөө, зохион байгуулалтын бүтцийг 16 орон тоотой байхаар шинэчлэн баталсан. Үүний дагуу аудитад хамрагдах хугацаанд тус байгууллага нь Захиргаа удирдлагын хэлтэс, Соёл, урлагийн хэлтэс нийт 16 албан хаагчийн бүтэц орон тоотой ТЗ ангилал зэрэглэлийн 13, төрийн үйлчилгээний 3 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй. Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 8 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх эрх бүхий ажилтан, баг зэргийг давхардуулан томилж, нийт 3 тушаалаар дотоод хяналтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- ✓ Даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/05 дугаар тушаалаар дотоод хяналтын ажилтан,
- ✓ Даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/06 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй баг,
- ✓ Даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/07 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын журам, дотоод хяналт шалгалтын баг, дотоод хяналтын ажилтны ажилтны байрны тодорхойлолт зэргийг баталсан байна.

Дээрх давхардуулан гаргасан тушаалыг хүчингүй болгож, даргын 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/03 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтын багийн ажиллах журам, багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсан байна.

Аудитад хамрагдах хугацаанд нийт 4 зорилтын хүрээнд 6 дотоод хяналт шалгалтыг хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож гаргаагүй, жилийн эцсийн байдлаар зохион байгуулсан ажлын талаар бичмэл тайлан гаргасан байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал: Байгууллагын санхүү байдлын тайлангаар нийт хөрөнгө 2025 онд 221,436.0 мянган төгрөг байна.

Санхүүгийн байдлын тайлан Хүснэгт 1 (мянган төгрөг)

Үзүүлэлт	2025 оны 12 сарын 31		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /3-2/
1	2	3	4
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	3,000.0	0
Бараа материал	16,470.3	22,056.5	5,586.2
Үндсэн хөрөнгө	124,633.5	340,483.3	215,849.8

Нийт хөрөнгө	141,103.8	362,539.8	221,436.0
Өглөг	0	8,890.9	8,890.9
ЗГ-ын оруулсан капитал	141,103.8	356,648.9	212,545.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгийн өмчийн дүн	141,103.8	362,539.8	221,436.0

Төсвийн төлөвлөлт:

Төсвийн шууд захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 610,547.7 мянган төгрөгөөр тооцож төлөвлөж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс нийт 38,250.3 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Үйл ажиллагааны санхүүжилтийн талаар:

Байгууллагын төсвийг нийт 572,027.4 мянган төгрөгөөр баталсан. Үүнээс улсын төсвөөс 572,027.4 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн. Гүйцэтгэлээр 569,022.9 мянган төгрөгийг зарцуулж, төвлөрүүлсэн дүн 3,004.4 мянган төгрөг байна.

Орон нутгийн төсвөөс нийт 90,856.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 80,892 мянган төгрөгийг зарцуулсан, мөн Нийслэлийн соёл урлагийн газраас 18,982.8 мянган төгрөгийн санхүүжилт олгон зарцуулсан байна.

Төсөвт хөрөнгийн зарцуулалтын талаар:

№	Эх үүсвэр	Төсвийн гүйцэтгэл		
		Хүснэгт 2(мянган төгрөг)		
		2025 оны 12 сарын 31		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	586,549.5	575,027.4	97.4
2	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585,549.5	571,022.5	92.6
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,343.6	456,007.6	99.7
4	Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	57,179.1	51,493.1	90.6
6	Хангамж, бараа материалын зардал	18,563.7	11,323.7	61
7	Томилолт зочны зардал	2000.0	2000.0	100
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	36,084.4	35,819.2	95.7
9	Бараа үйлчилгээний бусад зардал	14,378.7	14,378.7	100
10	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1000.0	1000.0	100
12	Төвлөрүүлсэн дүн		3,004.7	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	572,027.4	569,022.9	98.2
14	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	572,027.4	569,022.9	98.2

4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт

Бараа материалын талаар:

Бараа материал 2025 оны эхэнд 16,470.3 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 22,056.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал			Хүснэгт 3 (мянган төгрөг)		
Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэргийн материал	4,881.8	2,578.5	4,417.5	3,042.8
2	Аж ахуйн материал	11,455.3	27,825.9	20,400.7	18,880.5
3	Шатахуун	0	5,500.0	5,500.0	0
3	Сэлбэг хэрэгсэл	133,2	70,0	70,0	133,2
5	Барилгын засварын материал	0	0	0	0
6	Бусад хангамжийн материал	0	0	0	0
Дүн		16,470.3	35,974.4	30,388.2	22,056.5

Нийт бараа материалын 85.6 хувийг аж ахуй материал, 13.7 хувийг бичиг хэрэг үлдсэн 0,7 хувийг сэлбэг хэрэгсэл эзэлж байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 35,974.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 30,388.2 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар, зарлагын баримт үйлдэж зарцуулан тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө 2025 оны эхэнд 165,961.5 мянган төгрөг, тайлант онд 347,990.0 мянган төгрөгөөр нэмэгдэж жилийн эцсийн байдлаар 513,951.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө				Хүснэгт 4(мянган төгрөг)			
Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Авто тээвэр	67,500.0	-	-	67,500.0	17,812.5	49,687.5
2	Машин тоног төхөөрөмж	44,307.2	400,0	-	44,707.2	32,088.6	12,618.5
3	Тавилга эд хогшил	52,654.3	10,090	-	62,744.3	16,285.7	46,458.5
4	Бусад үндсэн хөрөнгө	0	337,500.0	-	337,500.0	105,937.5	231,562.5
5	Программ хангамж	1,500.0	-	-	1,500.0	1,343.7	156.2
Дүн		165,961.5	347,990.0	-	513,951.4	173,468.1	340,483.3

Нийт хөрөнгийн 68.0 хувийг бусад үндсэн хөрөнгө, 14.5 хувийг тээврийн хэрэгсэл, 13.6 хувийг тавилга эд хогшил, 3.7 хувийг машин тоног төхөөрөмж, 0.1 программ хангамж эзэлж байна.

Тайлант онд төсвөөс 16,900.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, Байгаль орчны газраас аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын дагуу 330,550.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна. Акталж, данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй.

4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Говь-Алтай аймгийн Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Санхүүгийн тайлангийн аудитаар 3 нэр төрлийн алдаа зөрчил илэрч албан шаардлага, 2 зөвлөмж,

нийцлийн аудитаар 1 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Хэрэгжилт 95 хувьтай байна.

Төрийн аудитаас 2024 онд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмж

Хүснэгт 5 (мянган төгрөг)

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн	Хэрэгжүүлсэн байдал
Зөвлөмж	Төсвөөс Ардын дуу бүжгийн Алтай чуулгад 1,000.0 мянган төгрөг, иргэн Д.Баянмөнхөд 300.0 мянган төгрөг, Ц.Батдэлгэрт 100.0 мянган төгрөг нийт 1,400.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Иргэн хуулийн этгээдэд төсвөөс дэмжлэг олгохгүй байж, батлагдсан төсвийг үр ашигтай захиран зарцуулж байх.	1,400.0	Дахин давтан гаргаагүй. Биелэлт 100 хувь.
Зөвлөмж	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин төсвөөс Соёл, урлагийн ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд 1,800.0 мянган төгрөгийг зарцуулсан. Баяр ёслол, уралдаан тэмцээн зохион байгуулах, бэлэг дурсгалын зүйл худалдан авахад төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.	1,800.0	Дахин давтан гаргаагүй. Биелэлт 100 хувь.
Зөвлөмж	Үндсэн орон тоонд түр томилгоотой төрийн үйлчилгээний 1, төрийн захиргааны 2 албан хаагчдад 4,138.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон. Түр орон тоонд ажиллаж байгаа албан хаагчдад тухайн албан тушаалын цалин олгож байх.	4,138.6	Дахин давтан гаргаагүй. Биелэлт 100 хувь.
Зөвлөмж	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг үнэн зөв иж бүрэн мэдээлж байх.	-	Тайлант онд 171 мэдээлэл оруулахаас 165 мэдээлэл хугацаандаа, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Биелэлт 80 хувьтай.
Нийт		7,338.6	

4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 6 мэдээ хугацаа хоцроосон.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”,

6 дугаар зүйлийн 6.1 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүн

Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг шинэчлэн батлах тухай” А/390 дүгээр тушаалын хавсралтаар “Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийг баталсан.

Дээрх аргачлалын дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн “Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн төсвийн хуваарилалт батлах тухай” А/212 дугаар тушаалаар төсвийн хуваарилалтыг баталж, тайлант онд Говь-Алтай аймгийн салбарын 22 байгууллага нийт 222,371.6 мянган төгрөгийн үр дүнд суурилсан санхүүжилтийг авч, 209,802.0 мянган төгрөгийг зарцуулж, 12,569.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6 (мянган төгрөг)

№	Байгууллагын нэр	Олгосон санхүүжилт	Нийт зарцуулалт	Зөрүү хэмнэлт, хэтрэлт
1	Ардын дуу бүжгийн Алтай чуулга	54,647.6	54,572.9	74.7
2	Жангар музей	21,806.4	21,614.4	192.0
3	Жангар нийтийн номын сан	12,649.6	12,645.9	3.7
4	Алтай сум соёлын төв	6,675.7	5,493.0	1,182.7
5	Баян-Уул сум соёлын төв	6,582.0	6,056.2	525.8
6	Бигэр сум соёлын төв	6,043.3	5,678.2	365.1
7	Бугат сумын соёлын төв	5,896.5	3,123.3	2,773.2
8	Дарив сум соёлын төв	7,589.7	7,423.9	165.8
9	Дэлгэр сум соёлын төв	10,876.0	10,265.9	610.1
10	Жаргалан сум соёлын төв	6,308.7	6,290.5	18.2
11	Тайшир сум соёлын төв	7,495.7	7,495.7	-
12	Тонхил сум соёлын төв	4,600.8	4,132.9	468.0
13	Төгрөг сум соёлын төв	14,360.1	14,099.3	260.8
14	Халиун сум соёлын төв	3,980.9	3,978.4	2.5
15	Хөхморьт сум соёлын төв	4,895.4	3,643.9	1,251.5
16	Цогт сум соёлын төв	7,029.4	3,672.0	3,357.4
17	Цээл сумын соёлын төв	2,728.7	2,301.6	427.1
18	Чандмань сум соёлын төв	8,783.5	8,783.5	-
19	Шарга сум соёлын төв	4,463.0	4,446.4	16.6
20	Эрдэнэ сумын соёлын төв	7,659.5	7,645.9	13.6
21	Баянтоорой тосгон соёлын төв	6,233.5	5,396.3	837.2
22	Гуулин тосгон соёлын төв	11,065.6	11,042.0	23.6
Нийт дүн		222,371.6	209,802.0	12,569.6

Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилт олгогдсоноор салбарын хэмжээнд санхүүжүүлэх боломжгүй үндсэн үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөр арга хэмжээ, дотоод үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

- ✓ Хөтөлбөр арга хэмжээнд 63,918.7 мянган төгрөг;

- ✓ Байгууллагын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалт 85,676.2 мянган төгрөг;
- ✓ Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 29,467.8 мянган төгрөг;
- ✓ Урамшуулал олгоход 30,739.4 мянган төгрөг тус тус зарцуулжээ.

5. АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр нууцын ажилтны ажил үүргийг хавсран гүйцэтгүүлж нийт 839.4 мянган төгрөгийн цалин хөлс олгосон.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр даргын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Б/20 дугаар тушаалаар Төлөвлөлт тайлагналт, мэдээлэл технологи, цахимжилын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Баасанжавд нууцын ажилтны ажил үүргийг хавсран гүйцэтгүүлж 40 хувийн нэмэгдэл олгосон.	
Шалгуур үзүүлэлт: Төрийн болон албаны нууцын тухай 14 дүгээр зүйлийн 14.1 "Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална" 29 дүгээр зүйлийн 29.1 "Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь нууц хамгаалах ажилтныг чөлөөлөх, өөр ажил, албан тушаалд шилжүүлэх бол тагнуулын байгууллагын саналыг авсан байна" 29.2 "Нууц хамгаалах ажилтанд харьцаж байгаа нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацааг харгалзан Засгийн газраас тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл олгоно" заалтуудад нийцээгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Дүрэм журмыг мөрдөөгүй.	
Үр нөлөө: Хууль, дүрэм журам зөрчигдөнө. Аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж авах эрсдэл үүснэ.	
Албан шаардлага: Зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх Санхүүгийн хяналт шалгалтын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.	

Илэрсэн асуудал 2	Өмч хамгаалах байнгын зөвлөл байхгүй. Шинээр худалдан авсан эд хөрөнгийг орлогод тусгах шийдвэр гаргаагүй.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: Өмч хамгаалах байнгын зөвлөл байхгүй. Шинээр худалдан авсан эд хөрөнгийг орлогод тусгах шийдвэр гаргаагүй.	
Шалгуур үзүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 65 дугаар тогтоолын хавсралт "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 5.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж, төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна" заалтуудад нийцээгүй байна.	
Асуудлын үндсэн шалтгаан: Дүрэм журмыг мөрдөөгүй.	
Үр нөлөө: Хууль, дүрэм журам зөрчигдөнө. Аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж авах эрсдэл үүснэ.	
Зөвлөмж: "Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг байгуулж, зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах. Зөвлөлийн шийдвэрийг гаргуулан, данс бүртгэлд тусгах тушаал шийдвэр гарган хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж байх.	

Илэрсэн асуудал 3	Шилэн дансны цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 6 мэдээ хугацаа хоцроосон.
Асуудлын ангилал	Нөлөө багатай
Бодит байдал: 6 мэдээлэл хугацаа хоцроосон.	
Шалгуур үзүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтад нийцээгүй.	
Асуудлын үндсэн шалтгаан: Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө: Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.	
Зөвлөмж: Давтан гаргахгүй байх. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх.	

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Тус байгууллага нь Ардын дуу бүжгийн Алтай чуулгын байранд байрлаж үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд тус онд хуучин театрын барилга байгууламжийг засаж тохижуулан өөрсдийн байртай болж ажилтан албан хаагчдад ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн орон нутгийн төсвөөс салбарын хэмжээнд нийт 1,305,000.0 мянган төгрөг төсвийг шийдүүлэн төлөвлөсөн үйл ажиллагаагаа бүрэн явуулсан байна.

Говь-Алтай аймгийн салбарын 22 байгууллага үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээр олгосон санхүүжилтийг арга хэмжээ хөтөлбөртэй бүрэн зарцуулахгүй, тус онд нийт 12,569.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хяналт шалгалтын явцад тус байгууллага нь өмч хамгаалах байнгын зөвлөл байгуулж ажиллаагүй, шинээр худалдан авсан болон шилжүүлж ирсэн хөрөнгийг бүртгэх тушаал шийдвэр гаргаагүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр нэмэгдэл хөлс олгосон зэрэг асуудал илэрлээ.

Иймд "Аудит, хяналт шалгалтаар илэрсэн асуудлуудын 20 хувь нь "нөлөө ихтэй" гэж үзсэн үед өгдөг "Хангалттай" үнэлгээг өгч, нийт 839.4 мянган төгрөгийн асуудал илэрсэн асуудалд 2 зөвлөмж өгч, 839.4 мянган төгрөгийн санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж байна.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ